



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/02/СТА-ТТЗ

Хаяг: Архангай аймаг,
Эрдэнэбулган сум. Аймгийн
ЗДТГ-ын байр “А” корпус, 3
давхар зүүн жигүүр.

Цахим хуудас: www.audit.mn

2021 он

Дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр

Утас: 70333141

Цахим хаяг: ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Байгалмаа

Утас: 70332860

Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Алтантуяа

Утас: 99338611

Цахим хаяг: altantuyan@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	2
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1. Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө	9
3.5.2 Авлага.....	10
3.5.3 Бараа материал	10
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.5 Өр төлбөр.....	12
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	13
3.5.7 Орлогын данс	13
3.5.8 Зардлын данс	14
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	18
3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	20
4. Менежментийн захидал.....	21
4.1. Орлогын данстай холбоотой асуудал.....	21
4.2 Балансын данстай холбоотой асуудал	21
4.3 Балансын данстай холбоотой асуудал	21
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын гэрчилгээ


**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ТАРИАТ СУМЫН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
Б.БУЯННЭМЭХ ТАНАА

СЭМ. 03.31 № 137
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Тариат сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариат сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилт 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	880,211.5	912,818.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	242,625.5	124,717.1
33	АВЛАГА	408,215.3	472,920.6
35	БАРАА МАТЕРИАЛ	229,370.8	315,180.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,249,050.2	6,238,308.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,249,050.2	6,238,308.2
39200	Биет хөрөнгө	6,060,453.8	6,051,778.6
39300	Биет бус хөрөнгө	188,596.3	186,529.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,129,261.7	7,151,126.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	211,822.6	285,054.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	211,822.6	285,054.7
41300	Өглөг	211,822.6	285,054.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,917,439.1	6,866,071.9
51	Засгийн газрын хувь оролцоо	6,917,439.1	6,866,071.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,341,144.9	2,341,144.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,600,513.4	1,549,190.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,975,780.9	2,975,736.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,129,261.7	7,151,126.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,389,891.6	3,386,599.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,033.4	185,476.9
110	Орлогын албан татвар	97,637.2	99,334.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	97,637.2	99,334.8
113	Хөрөнгийн албан татвар	6,030.0	7,350.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	79,366.2	78,792.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	406,447.3	414,484.4
120	Нийтлэг татварын бус орлого	406,447.3	414,484.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,800,410.9	2,786,638.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,348,486.8	3,298,610.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,348,486.8	3,298,610.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,827,376.2	3,195,137.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,491,607.4	1,810,334.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,528.0	233,016.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	486,225.8	455,486.2
2104	Хангамж, бараа материалын зардал	63,682.3	109,397.9
2105	Нормативт зардал	131,675.4	83,814.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,254.5	8,323.6
2107	Томилолт, зочны зардал	6,644.1	4,449.6

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,531.0	63,102.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	399,227.6	427,213.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	521,110.7	103,473.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	41,404.8	87,989.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	133,483.5	140,198.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-92,078.7	-52,209.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,250,271.4	3,100,437.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	183,033.4	185,476.9
110	Орлогын албан татвар	97,637.2	99,334.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	97,637.2	99,334.8
113	Хөрөнгийн албан татвар	6,030.0	7,350.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	79,366.2	78,792.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,762.6	25,068.8
1181	Газрын төлбөр	17,322.6	28,318.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	26,281.1	25,404.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	266,827.1	128,321.7
120	Нийтлэг татварын бус орлого	266,827.1	128,321.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,800,410.9	2,786,638.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,796,269.0	2,869,032.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,796,269.0	2,869,032.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,274,235.3	2,766,994.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,491,556.5	1,810,334.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,444.4	235,853.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,824.8	385,288.0
2104	Хангамж, бараа материалын зардал	60,698.6	82,852.4
2105	Нормативт зардал	150,779.0	91,364.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,549.4	24,110.0
2107	Томилолт, зочны зардал	6,644.1	4,449.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,211.2	60,360.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,527.3	72,382.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	522,033.7	102,037.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	454,002.4	231,405.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	195,892.0	175,101.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	195,892.0	175,101.1
2200	Дотоод эх үүсвэрээр	195,892.0	175,101.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-195,892.0	-175,101.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-172,000.0	-174,212.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	172,000.0	173,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	1,212.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	86,110.4	-117,908.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	156,515.1	242,625.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	242,625.5	124,717.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,009,517.8	7,009,517.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,009,517.8	7,009,517.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-
9	Тайлант үеийн үр дүн	(92,078.7)	(92,078.7)
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,917,439.1	6,917,439.1
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,917,439.1	6,917,439.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	886.7	886.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,918,325.9	6,918,325.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(44.7)	(44.7)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	(52,209.2)	(52,209.2)
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,866,071.9	6,866,071.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код€	Үзүүлэлт,	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,271,827.1	3,128,377.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,894,198.5	2,815,514.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,842,111.7	2,775,914.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,813,734.6	1,810,334.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	242,254.2	235,853.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,288.1	385,288.0
2104	Хангамж, бараа материалын зардал	81,209.5	80,491.0
2105	Нормативт зардал	141,459.7	91,364.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,910.0	28,910.0
2107	Томиллот, зочны зардал	4,459.5	4,449.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,891.6	72,219.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,904.5	67,004.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,086.8	39,600.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,086.8	39,600.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	201,134.9	139,862.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	176,493.7	173,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,271,827.1	3,058,943.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,880,245.7	1,809,361.1

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,026,506.1	1,127,698.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	365,075.3	121,884.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	138,152.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	67,506.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	156.5	153

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,318.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,318.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,318.7
2104	Хангамж, бараа материалын зардал	2,427.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,233.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,657.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,318.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,318.7
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,281.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,037.5

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Тариат сумын 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Б.Буяннэмэх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидлаар хүргүүлдэг.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсөв захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Н.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тариат сум нь тайлант жилд иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны удирдлагаар тасралтгүй хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжих зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоол
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам” ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар тогтоол
- “Автомашинны жишиг норм батлах тухай” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаал

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тариат сум нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

2020 онд ТЕЗ-ийн харъяа аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийсэн байна.

Харин Сумын төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

Тариат сумын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал / устгах бичилт хийгдсэн / 3,438,809.0 мянган төгрөгийн 1 хувь буюу 34,388.1 мянган төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 242,625.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 124,717.1 мянган төгрөг болж, 117,908.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банкинд байгаа мөнгө-Төрийн сан	241,413.1	124,717.1	(116,696.0)
Банкинд байгаа мөнгө-Арилжааны банк	1,212.4	0	(1,212.4)
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ЗДТГ	1,212.4	0	(1,212.4)
Орон нутгийн ерөнхий орлого	104,472.6	57,210.4	(47,262.2)
ОНХС	77,207.0	61,217.4	(15,989.6)
Сум хөгжүүлэх сан	59,733.4	6,289.3	(53,444.1)
Дүн	242,625.5	124,717.1	(117,908.4)

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 124,717.1 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд 117,908.4 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн ерөнхий орлого болон сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл өмнөх оноос буурсантай холбоотой байна.

Нийт мөнгөн хөрөнгийн 45.8 хувь буюу 57,210.4 мянган төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын дансны, 49.1 хувь буюу 61,217.4 мянган төгрөг нь ОНХСангийн, 5.1 хувь буюу 6,289.3 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл **408,215.2** мянган төгрөг, эцсийн үлдэгдэл **472,920.6** мянган төгрөг болж, **64,705.3** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбоотой авлага	22.7	1,251.7	1,229.0
Байгууллагаас авах авлага	0	1,631.3	1,631.3
Хувь хүнээс авах авлага	408,192.6	470,037.6	61,845.0
Дүн	408,215.3	472,920.6	64,705.3
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ИТХ	22.7	217.2	194.5
ЕБС	0	1,631.3	1,631.3
Хүүхдийн цэцэрлэг	0	370.5	370.5
Бага сургууль	0	664.0	664.0
ОНХС	1,612.0	55.0	(1,557.0)
Сум хөгжүүлэх сан	406,580.6	469,982.6	63,402.0
	408,215.3	472,920.6	64,705.3

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 64,705.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд СХС-ийн зээл олголт болон төсөвт байгууллагуудын авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт авлагын үлдэгдлийн 99.4 хувь буюу 469,982.6 мянган төгрөг нь СХС-ийн, 1,631.0 мянган төгрөг нь ЕБС-ийн, 217.2 мянган төгрөг нь ИТХ-ын, 370.5 мянган төгрөг нь хүүхдийн цэцэрлэгийн, 664.0 мянган төгрөг нь бага сургуулийн, 55.0 мянган төгрөг нь ОНХС-ийн авлага байна.

СХСангийн зээлийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 383,815.1 мянган төгрөг буюу 81.7 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 4,773.9 мянган төгрөг буюу 1.0 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 81,393.5 мянган төгрөг буюу 17.3 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэхээр засаг даргын зүгээс хугацаатай мэдэгдэл хүргүүлэн, шүүхэд шилжүүлэн ажилласан байна.

Илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангаас олгосон 86,167.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.
- Төсөвт байгууллагууд нь нийт ажилчид болон байгууллагаас авах авлага үүсгэсэн байна.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 229,370.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 315,180.8 мянган төгрөг болж, 85,810.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	55,854.2	94,942.1	39,087.9
Хангамжийн материал	171,866.5	218,613.7	46,747.2
Мал амьтад	1,650.0	1,625.0	(25.0)
Дүн	229,370.7	315,180.8	85,810.1
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ИТХ	2,135.0	3,568.5	1,433.5
ЗДТГ	52,096.5	81,928.5	29,832.0
ЕБС	112,032.3	171,861.7	59,829.4
Хүүхдийн цэцэрлэг	39,874.9	22,299.4	(17,575.5)
Бага сургууль	9,996.0	21,364.1	11,368.1
Соёлын төв	13,236.0	14,158.6	922.6
	229,370.7	315,180.8	85,810.1

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 85,810.1 мянган төгрөгөөр өссөн нь түүхий эд материал дансанд тайлагнагдсан тусгай зориулалтын материал болон хангамжийн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт бараа материал үлдэгдлийн 54.5 хувь буюу 171,861.7 мянган төгрөг нь ЕБС-ийн, 7.1 хувь буюу 22,299.4 мянган төгрөг хүүхдийн цэцэрлэгийн, 29.1 хувь буюу 81,928.5 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 6.8 хувь буюу 21,364.2 мянган төгрөг нь бага сургуулийн, 4.8 хувь буюу 14,158.6 мянган төгрөг нь соёлын төвийн, 1.0 хувь буюу 3,568.5 мянган төгрөг нь сумын ИТХ-ын бараа материалын үлдэгдэл тус тус байна.

Бараа материалын данс нь оны эхэнд 229,370.7 мянган төгрөг ба тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 289,548.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 59,852.5 мянган төгрөг, шилжүүлэн авсан 17,608.5 мянган төгрөг нийт 367,009.8 мянган төгрөгөөр нэмэгдэн, зарцуулсан 241,495.2 мянган төгрөг, шилжүүлэн 17,608.5 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 315,180.8 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт бараа материалын 69.4 хувийг хангамжийн материал, 30.1 хувийг тусгай түүхий эд материал, 0.5 хувийг мал амьтад эзэлжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,249,050.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6,238,308.2 мянган төгрөг болж, 10,742.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,060,453.8	6,051,778.6	(8,675.2)
Биет бус хөрөнгө	188,596.4	186,529.8	(2,066.4)
Дүн	6,249,050.2	6,238,308.2	(10,742.0)
Үүнээс, байгууллагын төрлөөр:			
ИТХ	3,352.9	13,028.2	9,675.3

ЗДТГ	2,412,950.8	2,459,035.5	46,084.7
ЕБС	1,875,195.3	1,853,588.2	(21,607.1)
Хүүхдийн цэцэрлэг	619,527.4	609,695.1	(9,832.3)
Бага сургууль	604,389.6	586,534.0	(17,855.6)
Соёлын төв	733,634.2	716,427.3	(17,206.9)
	6,249,050.2	6,238,308.2	(10,742.0)

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 29.7 хувь буюу 1,853,588.2 мянган төгрөг нь ЕБС-ийн, 9.8 хувь буюу 609,695.1 мянган төгрөг хүүхдийн цэцэрлэгийн, 39.4 хувь буюу 2,459,035.5 мянган төгрөг нь ЗДТГ-ын, 9.4 хувь буюу 586,534.0 мянган төгрөг нь бага сургуулийн, 11.5 хувь буюу 716,427.3 мянган төгрөг нь соёлын төвийн, 0.2 хувь буюу 13,028.2 мянган төгрөг нь сумын ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тус тус байна.

Үндсэн хөрөнгө данс нь тайлант оны эхэнд 6,249,050.2 мянган төгрөг ба төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 35,238.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 344,807.3 мянган төгрөг, бусад 3,600.0 мянган төгрөг нийт 383,645.8 мянган төгрөгөөр нэмэгдэн, үндсэн хөрөнгө акталсны гарз 335.9 мянган төгрөг, тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 394,051.9 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 6,238,308.2 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 97.0 хувийг биет хөрөнгө, 3.0 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Илрүүлэлт:

- ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 53 нэр төрлийн 57,405.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн 8,173.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 6 нэр төрлийн 48,270.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.
- ЗДТГ-ын бусад үндсэн хөрөнгөнд 49,820.0 мянган төгрөгийн зам давааны засварын ажлыг орлогод авч үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэснийг залрууллаа.
- ЗДТГ-ын биет бус хөрөнгөнд сумын ЕБС, хүүхдийн цэцэрлэгт ашиглагдаж байгаа тус бүр нь 1,200.0 мянган төгрөгтэй нийт 2,400.0 мянган төгрөгийн өртөгтэй СИ ТИ ЭС санхүүгийн программ бүртгэлтэй байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 211,822.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 285,054.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 73,232.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	211,822.6	285,054.7	73,232.1
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-
Дүн	211,822.6	285,054.7	73,232.1
Үүнээс, байгууллагын төрлөөр:			

ЕБС	201,729.7	275,100.5	73,370.8
ЗДТГ	1,212.4	23.0	(1,189.4)
Соёлын төв	6,592.0	9,931.3	3,339.3
Бага сургууль	2,288.5	-	(2,288.5)
Дүн	211,822.6	285,054.7	73,232.1

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн 96.5 хувь буюу 275,100.5 мянган төгрөг нь ЕБС-ийн, 3.5 хувь буюу 9,931.0 мянган төгрөг нь Соёлын төвийн өр байна.

ЕБС болон Соёлын төвийн нийт 285,031.8 мянган төгрөгийн өглөг нь сумын төвийн шинэчлэлийн ажлын хүрээнд нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Адуучин удам ХХК-д өгөх “халаалтын өр” байна.

Богино хугацаат өр төлбөрийн нийт үлдэгдэл нь бүгд байгууллагад төлөх өглөг байна. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Илрүүлэлт:

- Сумын ЕБС-Өмнөх оны аудитаар өгсөн өр төлбөрийг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй буюу тайлан оны эцэст халаалтын өглөг 275,100.4 мянган төгрөг болж өмнөх оноос 73,370.8 төгрөгөөр өссөнд өр төлбөрийг барагдуулах талаар зөвлөмж хүргүүлсэн.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,917,439.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 6,866,071.9 мянган төгрөг болж, 51,367.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,341,144.9	2,341,144.9	-
Хуримтлагдсан үр дүн	1,600,513.3	1,549,190.9	(51,322.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,975,780.9	2,975,736.2	(44.7)
Дүн	6,917,439.1	6,866,072.0	(51,367.1)

Эх сурвалж: Тариат сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 51,367.1 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн болон хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү буурснаас шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,386,599.8 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 3,291.8 мянган төгрөгөөр буурсан байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 185,476.9 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 414,484.4 мянган төгрөг тайлагнагдсаны 5,230.0 мянган төгрөг нь торгуулийн орлого, 408,047.2 мянган төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 1,207.5 мянган төгрөг нь бусад орлого байна. Үүнээс төсөвт байгууллагын өөрийн орлогыг задалж авч үзвэл үндсэн үйл

ажиллагааны орлого 9,887.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 398,159.8 мянган төгрөг тус тус байна.

3. Тусламж санхүүжилтийн орлого 2,786,638.4 мянган төгрөгөөр тайлагнасныг нэр төрлөөр нь задалж авч үзвэл: тусгай зориулалтын шилжүүлгээс 1,871,180.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 26,338.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 889,119.1 мянган төгрөг тус тус байна.

3.5.8 Зардлын данс

Сумын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны зардал 3,298,610.6 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 140,198.4 мянган төгрөг, нийт 3,438,809.0 мянган төгрөгийн зардал тайлагнасан байна. Өмнөх оноос бараа үйлчилгээний урсгал зардал 367,761.3 мянган төгрөгөөр өссөн нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Илрүүлэлт:

- ИТХ- 289.0 мянган төгрөгийн материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасанд зөвлөмж хүргүүлсэн.
- ИТХ- 300.4 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- ЗДТГ- тээвэр шатахууны зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт алдагдсан буюу жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, норм бодож хэтрэлт, хэмнэлтийг тооцоогүйтэй холбоотой 23,390.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэн ажилласан.
- ЗДТГ- 991.3 мянган төгрөгийн цалинг илүү тооцож олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- ЗДТГ- Мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлыг 1212.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залруулсан.
- Сумын төсөвт байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлтийн талаар:

Орон нутгийн төсвийн орлогыг 113,590.5 мянган төгрөгөөр анх төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлснийг 10,266.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 123,857.0 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд аймгаас хөрөнгийн орлогыг 4,500.0 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогыг 2,500.0 мянган төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 980.0 мянган төгрөг, хог хаягдлын хураамжийг 3,000.0 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийг 3,677.5 мянган төгрөг, ус рашаан ашигласны төлбөрийг 600.0 мянган төгрөг, нэр заагдаагүй бусад орлогыг 400.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, харин шууд бус орлогыг 4,400.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлогыг 780.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Харин төсвийн тодотголоор нийт орлогыг 14,630.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ба аймгаас шууд бус орлогыг 18,600.0 мянган төгрөгөөр АРА-2021/02/СТА-ТТЗ

нэмэгдүүлэн, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 810.0 мянган төгрөгөөр, ойн нөөц ашигласны төлбөрийг 3,108.0 мянган төгрөгөөр, ан амьтаны нөөц ашигласны төлбөрийг 52.0 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгосон байна.

Тариат сумын ИТХ-ын 2020 оны төсөв батлах тогтоолоор сумын нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг **3,263,027.6** мянган төгрөгөөр анх баталсан бол тодотгосон тогтоолоор **3,219,877.1** мянган төгрөг болж **43,150.5** мянган төгрөгөөр бууруулсан байна.

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн зарим нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан бол Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын /сургууль, цэцэрлэг/ үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс 87,972.7 мянган төгрөгөөр тус тус хасаж тодотгол хийгдсэн байна.

Хүснэгт 7. Сумын төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	123,857.0	138,487.0	14,630.0
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	214,255.5	182,295.7	(31,959.8)
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	341,871.7	315,825.7	(26,046.0)
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	125,457.3	122,315.9	(3,141.4)
5	СӨБ-ийн үйлчилгээ	504,493.7	439,640.0	(64,853.7)
6	ЕБС-ийн үйлчилгээ	1,767,872.8	1,744,753.8	(23,119.0)
7	Соёлын үйлчилгээ	94,879.4	94,879.4	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	-	-	-
9	2019 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	83,140.0	104,472.6	21,332.6
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	7,200.2	77,207.0	70,006.8
	Нийт дүн	3,263,027.6	3,219,877.1	(43,150.5)
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	69,747.1	71,847.1	2,100.0
2	Засаг даргын тамгын газар	479,121.6	486,938.2	7,816.6
3	Орон нутгийн хөгжлийн сан	174,092.7	201,134.9	27,042.2
4	Сум хөгжүүлэх сан	170,320.3	178,183.7	7,863.4
5	Сургуулийн өмнөх боловсрол	504,493.7	439,640.0	(64,853.7)
6	Ерөнхий боловсролын сургууль	1,767,872.8	1,744,753.8	(23,119.0)
7	Соёлын төв	97,379.4	97,379.4	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	-	-	-
	Нийт дүн	3,263,027.6	3,219,877.1	(43,150.5)

✓ **Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Тариат сумын ИТХ-ын 2020 оны сумын 2020 оны төсөв тодотгон батлах тухай 05-р тогтоолд сумын төсвийн орлогоор 16 нэр төрлийн 138,487.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 192,224.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 138.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Сумын орон нутгийн төсвийн орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	138,487.0	192,224.2	53,737.2	138.8
2.УРСГАЛ ОРЛОГО	138,487.0	192,224.2	53,737.2	138.8
3.ТАТВАРЫН ОРЛОГО	121,487.0	185,476.9	63,989.9	152.7
4.Орлогын албан татвар	58,850.0	99,334.8	40,484.8	168.8
Хүн амын орлогын албан татвар	58,850.0	99,334.8	40,484.8	168.8
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар			0.0	
Үйл ажиллагааны орлого	5,000.0	5,047.0	47.0	100.9
Хөрөнгийн орлого	31,500.0	48,065.6	16,565.6	152.6
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	150.0	1,433.8	1,283.8	955.9
Шууд бус орлого	22,200.0	44,788.4	22,588.4	201.7
Өмчийн татвар	7,185.0	7,350.0	165.0	102.3
Үл хөдлөх хөрөнгийн татвар			0.0	
Бууны албан татвар	7,185.0	7,350.0	165.0	102.3
Бусад татвар	55,452.0	78,792.1	23,340.1	142.1
Улсын тэмдэгтийн хураамж	5,000.0	3,625.2	-1,374.8	72.5
Газрын төлбөр	7,720.0	28,318.5	20,598.5	366.8
-----газрын төлбөр		1,397.6	1,397.6	
-----Газрын дуудлага худалдааны орлого	7,720.0	26,920.9	19,200.9	348.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,120.0	4,444.0	1,324.0	142.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15,512.0	16,999.6	1,487.6	109.6
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	24,100.0	25,404.8	1,304.8	105.4
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	146.0	1,193.0	1,047.0	817.1
----- ус рашааны нөөц ашигласны төлбөр	1,600.0	1,650.0	50.0	103.1
-----ойн нөөц ашигласны төлбөр	21,922.0	22,011.8	89.8	100.4
-----ан амьтаны нөөц ашигласны төлбөр	432.0	550.0	118.0	127.3
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,000.0	6,747.3	-10,252.7	39.7
Төсөвт газрын өөрийн орлого	1,100.0	310.0	-790.0	28.2
Хүү торгуулийн орлого	15,000.0	5,230.0	-9,770.0	34.9
Нэр заагдаагүй бусад орлого	900.0	1,207.3	307.3	134.1

Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,374.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 9,770.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 790.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь сумын иргэний бүртгэлийн үйлчилгээ цахимжиж, уг үйлчилгээнээс төвлөрдөг тэмдэгтийн хураамж аймагт төвлөрдөг болсон, коронавирус /Ковид-19/ цар тахал гарсантай холбогдуулан хорио цээрийн дэглэм тогтоож, зорчих хөдөлгөөн багассан, мөн ил задгай худалдаа үйлчилгээ явуулах зөвшөөрөл өгөөгүйтэй холбоотой байна.

✓ **Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Тариат сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тогтоолоор 3,263,027.6 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсөвт тодотгол хийж, ИТХ-д

2,100.0 мянган төгрөг, ЗДТГ-т 7,816.6 мянган төгрөгийн, ОНХС-д 27,042.2 мянган төгрөг, СХС-д 7,863.4 мянган төгрөгийн нэмэх, СӨБ-т 64,853.7 мянган төгрөг, ЕБС-д 23,119.0 мянган төгрөгийн хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 3,219,877.1 мянган төгрөгөөр баталжээ.

Харин аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС-ийн халаалтын өрийг шийдвэрлэхэд 51,950.0 мянган төгрөгийг нэмэгдүүлэн батлан өгч сумын төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 3,271,827.1 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,271,827.1 мянган төгрөгийн төлөвлөснөөс 2,894,198.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 201,134.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 176,493.7 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар төлөвлөж, нийт зардлын 1,880,245.7 мянган төгрөг буюу 57.5 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 1,026,506.1 мянган төгрөг буюу 31.3 хувийг орон нутгийн төсвөөс, 365,075.3 мянган төгрөг буюу 11.2 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр хуваарилсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,128,377.3 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь урсгал зардлаас 78,683.8 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 61,272.3 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангаас 3,943.7 мянган төгрөг тус тус хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХС-ийн хөрөнгөөр 15 төсөл, арга хэмжээнд 201,134.9 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 139,862.6 мянган төгрөгийг 12 төсөл арга хэмжээнд зарцуулж, 2 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй ба энэ нь тендерийг 2 удаа зарласан боловч оролцогч ирээгүйгээс тендер хүчингүй болж, цаг агаар хүйтэрсэнтэй холбоотой байна.

Илрүүлэлт:

ЕБС нь төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан бүрэлдэхүүн хэсгийг хуулиар заасан хугацаанд иж бүрэн ирүүлээгүй, зөвхөн эдийн засгийн ангиллаарх төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайлбар тодруулгыг бэлтгээгүй, төсвийн тохируулгын тайланг Сангийн сайдын батлагдсан маягт аргачлалын дагуу бэлтгээгүй зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 20,281.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,057.5 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж 4,000.0 мянган төгрөг нийт 26,338.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2,427.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 5,233.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,657.6 мянган төгрөг, 20.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 162 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 , хугацаа болоогүй 2 , хугацаа хоцроосон 8 мэдээллийг тус тус шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Илрүүлэлт:

- ЕБС- Шилэн дансны цахим хуудсанд 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд зөвлөмж хүргүүлсэн.
- ЗДТГ- Шилэн дансны цахим хуудсанд 26 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, дараа жилийн төсвийн төсөл, ЗДТГ-ын дарга болон сумын засаг даргын мөнгө, хөрөнгө зарцуулахтай холбоотой 13,531.0 мянган төгрөгийн 11 тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байсанд албан шаардлага хүргүүлэн ажилласан.
- ИТХ - Шилэн дансны цахим хуудсанд 23 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд зөвлөмж хүргүүлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 176,365.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж-ОНО	1	3,461.3	1	3,461.3			100
Зөвлөмж-СХСан	1	172,904.4	1	86,737.0	1	86,067.4	60
Нийт	2	176,365.7	2	90,198.3	1	86,067.4	80

СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар албан бичгээр зөвлөмжийн хариуг ирүүлсэн бөгөөд энэ жил хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос 86,737.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байгаа тул биелэлтийг 60 хувьтай байна гэж үзэн тайлант оны аудитаар дахин зөвлөмж хүргүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Мөн өмнөх онд 4 нэр төрлийн орлого тасарсанд зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулсан бөгөөд энэ онд өмнөх онд тасарсан 4 нэр төрлийн орлогоос өөр 4 нэр төрлийн орлого тасарсан тул дахин зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Тариат сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Тариат сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №10. Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн			Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1			1		1		
Хүүхдийн цэцэрлэг	1	1			1					
Бага сургууль	1	1		1						
ЗДТГ	1	1	1			1	1			
ИТХурал	1	1	1			1	1			
Соёлын төв	1	1		1						
ОНХС	1	1		1						
СХС	1	1		1						
НИЙТ ДҮН	8	8	3	4	1	3	2	1	0	0

Сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллагад итгэл үзүүлэн, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, харин Ерөнхий боловсролын сургуульд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 480,883.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 51,032.3 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1,291.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,921.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 391,638.7 мянган төгрөгийн 8 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өгч ажилласан байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 89.4 хувийг залруулагдаагүй, 10.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Хүснэгт №11. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЕБСургууль			3	275,100.4			1	-	2	275,100.4
ЗДТГ	2	51,032.3	6	154,161.8	1	991.3	2	36,921.2	3	116,249.3
ИТХурал			4	589.4	1	300.4			3	289.0
НИЙТ ДҮН	2	51,032.3	13	429,851.6	2	1291.7	3	36,921.2	8	391,638.7

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал НББ тайлагналтай холбоотой 190,960.8 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 1,291.7 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 288,631.4 мянган төгрөгийн алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Тариат сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 98,102.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, менежмент захидлаар зөвлөмж хүргүүлээ.

Хүснэгт №12 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сум хөгжүүлэх сан	1	86,167.4					1	86,167.4
ОНОрлого	1	11,934.8					1	11,934.8
Нэгдсэн тайлан	1	-					1	-
НИЙТ ДҮН	3	98,102.2					3	98,102.2

- Орон нутгийн орлогод 16 нэр төрлийн 138,487.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 192,224.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 138.8 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,374.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 9,770.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 790.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан тул аудитаас орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмжийг сумын удидлагад хүргүүллээ.
- СХС-ийн 469,982.6 мянган төгрөгийн авлагатайгаас 383,815.1 мянган төгрөг буюу 81.7 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 4,773.9 мянган төгрөг буюу 1.0 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 81,393.5 мянган төгрөг буюу 17.3 хувь нь чанаргүй зээл эзэлж байгаа тул холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг сумын удидлагад хүргүүллээ.
- Сумын нийт өр төлбөрийн 96.5 хувь буюу 275,100.5 мянган төгрөг нь ЕБС-ийн, 3.5 хувь буюу 9,931.0 мянган төгрөг нь соёлын төвийн өр бөгөөд энэ нь нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой 2019,2020 онд үүссэн байгууллагад төлөх өр байна. Тус өр төлбөрийг барагдуулах талаар сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлсэн эсэх, мөн СХС-ийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан эсэх, мөн өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нягтлан шалгана.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Орлогын данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,374.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 9,770.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 790.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.1.2 Эрсдэл:

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч, төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

4.2 Балансын данстай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас олгосон 86,167.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг зөрчсөн байна.

4.2.2 Эрсдэл:

Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

4.3 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.3.1 Илрүүлэлт:

Сумын ЕБС болон соёлын төвийн нийт 285,031.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр нь тус суманд хэрэгжсэн сумын төвийн шинэчлэлийн ажлын хүрээнд нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой “Адуучин удам”ХХК-д өгөх халаалтын өр байна.

4.3.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчигдөх

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Сумын удирдлагын зүгээс өр төлбөрийг барагдуулах талаар шат дараатай тодорхой арга хэмжээг авч ажиллах

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

Н.Алтантуяа

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер

Т.Байгалмаа

Хоёр дахь шатанд хянасан:

Тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын вэр:	Архангай аймгийн Тариат сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: АРА-2021/02/СТА-ТГЗ
Шалгагдсан байгууллагын вэр:	Тариат сумын ТЕЗ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	тоо	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Сум хөгжүүлэх сангаас олгосон 86,167.4 мянган төгрөгийн 18 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэлтэй байна.	1	86,167.4	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Тариат сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Буяннэмэх, Б.Баттогтох
2	Тайлант жилд 13 нэр төрлийн орлого давж биелэсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,374.8 мянган төгрөгөөр, хүү торгуулийн орлого 9,770.0 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 790.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.	1	11,934.8	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Тариат сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Буяннэмэх, Б.Баттогтох
3	ЕБС болон соёлын төвийн нийт 285,031.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр нь тус суманд хэрэгжсэн сумын төвийн шинэчлэлийн ажлын хүрээнд нэгдсэн халаалтанд шилжсэнтэй холбоотой Адуучин удам ХХК-д өгөх “халаалтын өр” байна	1	-	Сумын удирдлагын зүгээс тодорхой арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөх	Тариат сумын засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Буяннэмэх, Б.Баттогтох
	Дүн	3	98,102.2			